

БАТЛАВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА  БАТАНБААР

2025 оны 05 дугаар сарын 01 --ны өдөр

ХҮН АМЫН ТЭРГҮҮЛЭХ ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТЫГ БУУРУУЛАХ "HEARTS" ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

2025.05.01

Арвайхээр сум.

Зорилго:

Эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгааны ажил, гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх, аймгийн хүн амын дунд өвчлөл, нас баралтын 50 хувийг эзэлж буй зүрх судас, чихрийн шижингийн нотолгоонд HEARTS удирдамжийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх зорилготой.

Зохион байгуулагч:

Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлтийн хэлтэс

Хамрах хүрээ:

Өвөрхангай аймгийн эрүүл салбарын их эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүд

Сэдэв: Зүрх судас, чихрийн шижингийн оношлогоо эмчилгээний багцын хүрээнд:

1. Н-Эрүүл амьдралын хэв маягийн зөвлөгөө
2. Е- Нотолгоонд тулгуурласан эмчилгээний протокол
3. А- Зайлшгүй шаардлагатай эм, багаж хэргслийн хангалт
4. R-Эрсдэлд суурилсан зүрх судасны өвчний менежмент
5. Т-Багт суурилсан тусламж үйлчилгээ
6. S- Хяналтад зориулсан систем

Судалгааны бичмэл тайланд тавигдах ерөнхий шаардлага:

- HEARTS удирдамжийн онол, арга зүйн үндэслэлтэй;
- Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан,
- Статистикийн арга хэрэгслүүдийг ашигласан;
- Судалгааны 2 буюу түүнээс дээш аргыг ашиглаж, үр дүнг тодорхой дурьдсан,
- Судалгаанд ашигласан материалыг бүрэн дурдсан
- Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, дүгнэлт, зөвлөмжид хүрсэн байх;

Бичгийн стандарт:

- Үсгийн фонд – Times New Roman /"Mon" өргөтгөлтэй фонт байж болохгүй/
- Фонтын хэмжээ -12;
- Мөр хоорондын зай-1,5;
- Margins: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм;
- Үсгийн фонд – Times New Roman
- Үсгийн өндөр 12 pt

- Мөр хоорондын зай 1,5 Single байна.
- Хуудас:дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм,
- Цаасны хэмжээ : A4
- Бүтээлийн хуудасны тоо : 30 нүүрнээс ихгүй,
- Судалгааны хураангуйг бичсэн байх,
- Нүүр хуудсанд нэр, холбоо барих 2 утасны дугаар, и-мэйл хаяг, ажлын болон сургуулийн нэр, курс, мэргэжил, судалгааны ажлын нэрийг бичих
- Үг, үсгийн болон утга найруулгын алдаагүй байх
- Судалгааны бичмэл тайлан нь гарчиг, хураангуй, удиртгал, судалгааны хэсэг, дүгнэлт ном зүй гэсэн үндсэн хэсгүүдийг багтаасан байх
- Оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах)

Зохион байгуулалт:

- Зохион байгуулах комисс бүтээлийг хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээн авч судалгааны ажлыг дүгнэх
- Шалгарсан судалгааг онол практикийн бага хуралд оролцуулна. Илтгэх хугацаа 15 минут, Power point хэлбэрээр бэлтгэж, танилцуулна.
- Санаагаа ойлгомжтой, цэгцтэй хүргэх
- Асуултанд оновчтой хариулах
- ЭМГ, БОЭТ, бусад байгууллагаас эрдэмийн цол, боловсролын зэрэгтэй шүүгч нарын багаар шүүлгэж дүнг гаргах, шалгарсан бүтээлийг Эрүүл мэндийн газрын вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээнэ.

Шагналын сан:

- 1 -р байр өргөмжлөл, 800,000 төгрөг
- 2-р байр өргөмжлөл, 500,000 төгрөг
- 3-р байр өргөмжлөл, 300,000 төгрөг

Материал хүлээн авах хугацаа:


Өөрийн нэр, албан тушаал, утасны дугаараа бичиж [/hvrelchuluundulamhand@gmail.com/](mailto:hvrelchuluundulamhand@gmail.com) хаягаар 2025 оны 05-р сарын 26 -ны дотор ирүүлнэ үү.

Хугацаа:

2025 оны 05-р сарын 29-нд Онол практикийн бага хурал зохион байгуулагдана. Тухайн өдрийн ОПБХ болох байршил, цагийг өмнөх өдрүүдэд зарлаж мэдээлнэ

Хүрэх үр дүн:

Эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгааны ажил, гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлж, нотолгоонд суурилсан зүрх судас, чихрийн шижингийн өвчлөл, нас баралтыг бууруулах практик ач холбогдолтой аргыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд багц байдлаар нэвтрүүлсэн байна.

БОЛОВСРУУЛСАН:
УТХ-ИЙН ДАРГА  Н.ОЮУНТУЯА

ЗАРЦУУЛАГДАХ САНХҮҮГИЙН ТООЦОО

№	Зардлын нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ ₮	Нийт үнэ ₮
1	Оролцогчдын цайны зардал	100 оролцогч	10,000	1000,000
2	Шүүгчдийн ажлын хөлс	5 шүүгч	100,000	500,000
3	Нийт илтгэгч нарт	20 илтгэгч	70,000/ багаж хэрэгсэл/	1,400,000
4	Шагнал урамшуулалд	3 байр	1-р байр – 800,000 2-р байр- 500,000 3-р байр -300,000	1,600,000
5	Зочин илтгэгчийн зардал	1	1000,000	1000,000
6	НИЙТ			5,500,000

ЗАРДЛЫН ТООЦООГ ГАРГАСАН:

УТХ-ИЙН ДАРГА  Н.ОЮУНТУЯА